

МОНГОЛЫН "АРДЧИЛАЛ" ЯАГААД АНАРХИ РҮҮ ГУАСАВ

*МУИС, ОУХС-ийн захирал
доктор (Ph.D) Хиад Ж.Бор*

Монголчууд бид ардчиллыг арван жилийн өмнөөс эхлэн урам зориг, идэвхи зүтгэл, сэтгэлийн хөдөлгөөнтэйгөөр барьж төлөвшүүлэн, нийгэмдээ суулгаж эхэлсэн билээ. Гэвч бид ХХ зууны Монголчуудын онцлог болсон хэт дууриан хэлбэрдэх зангаараа энэ удаа ч гэсэн өөрсдийнхөө сэтгэлгээний үндэстэний онцлог Монгол орны өвөрмөц онцлогийг ухаарч ойлгон тэр их үйлсдээ тусган суулгаж, харийн шинэ зүйлээ авахыг нь авч гээгдүүлэхийг нь гээгдүүлж зөв зүйтэйгээр хийж хэрэгжүүлж чадсангүй. Бас л хольцоолгүй дууриаж, бас л хэт хэлбэрдэж, бас л алдаж орхижээ. Өрнө дахин нийгмийн их зөвшилгийг бий болгож удаан хугацаагаар амьд байлгахдаа төр улсын оршин тогтнолыг хэврэгшүүлэлгүйгээр сөрөг хүчин оршин тогтнодог, түүнийг нийгэмд хүлээн зөвшөөрдөг нөхцлийг бүрдүүлэн улс төрийн олон давхаргат нийгэмд олон ургалч үзэл цэцэглэн хөгжих бололцоог олж авсан юм. Өөрөөр хэлбэл олон ургалч нийгмийг хоорондоо өрсөлдөгч хүмүүс (удирдагчид, лидерүүд) ба бүлэглэлүүдийн маргаан зөрчилд тодорхой зааг хязгаар тавьдаг тулгар үнэт зүйлсийн хоорондыг зөвшил эвлэрэлгүйгээр төсөөлөхийн ч аргагүй билээ. Гэтэл Монголд тийм зөвшил эвлэрэл тун сул байв. Ардчилсан хувьсгал хэдэн арван жил оршин тогтносон ниймийн бүтцийг хэт хурдаат эвдсэнээс улс төрийн туршлага муутай өрсөлдөгч бүлэглэлүүдийг л гаргаж ирсэн юм.

Нөгөөтэйгүүр ардчиллыг нийгэмдээ дөнгөж төлөвшүүлж эхэлж буй улс үндэстэнд сөрөг хүчин үндэстэний оршин тогтнолд нийгмийг бутаргах аюул залж болзошгүй байдаг билээ. Нэг ялангуяа үндэстэний тусгаар тогтнолын баталгааны тор болж өгдөг иргэний нийгэм бүрэлдээгүй нөхцөлд энэ аюул улам ч их байдаг. Энэ нөхцөлд сөрөг хүчин ба урван тэрсэлэлт хоёрыг нэгэн ижил зүйл гэж ойлгох ухамсар хамгийн хүчирхэг бөгөөд бүхний дарангуйлагч үзэл болдог. Монголын өнөөгийн төр, нийгмийн анархи байдлын улмаас Монгол орон хэдийгээр иргэний нийгэмтэй

АЛТАН АРГАМЖ

ч Тоталитар дэглэмээс өвлөж авсан энэ мэт зүйлс манай нийгэмд ардчиллын үед ч амь бөхтэйгээ харуулсаар байна.

Өрнөдийн ардчилал нь Монголчуудын XIII зуунаас улбаалсан ардчиллын уламжлалтай зэрэгээр авцалдаж байсан боловч Монголд социализмын үед бүрэлдэн тогтсон ухамсрын өвтэй зөрчилдөж байсан юм.

Өөрөөр хэлбэл Монголын хувьд нийгэмдээ ардчиллыг төлөвшүүлэх үед өрнөдийн оюуны үнэт зүйлс ба Монголын соёлын уламжлал хоёрын хооронд далд зөрчил эхлэн улмаар гүнзгийрсэн юм. Түүгээр ч барахгүй энэ их үйл явцыг өрнүүлэхдээ бид хийж болшгүй олон олон алдаа эндэгдлийг үйлджээ.

Нэгд, өрнөдийн маягийн ардчилсан засаглалыг гаргаж ирэхдээ парламентын засаглалын зүрх болсон "парламент"-ийг гаргаж ирж чадсан боловч түүний амин сүнс болсон ард түмнээс парламентэд эргэж нөлөөлөх лоббийн хөшүүргийг бий болгосонгүй. Тиймээс парламентэт засаглалын нэг гол механизм доголдон ажиллахгүй болсон гэж хэлж болно.

Хоёрт, олон намын тогтолцоог бий болгохдоо зөвхөн улс төрийн өрсөлдөгчдийн хэмжээнд өрсөлдөж байдаг сэтгэлгээгээр гаргаж ирсэнгүй, харин бие биеэ хэт үзэн ядах сэтгэлгээнд дүлдүүдсанаас үндэстэний хэмжээний дайсгалыг орон даяар бий болгоод байна. Энэ нь дээр хэлсэнээр улс орны тусгаар тогтнолыг хэврэгшүүлэх хүчин зүйл болж өгч буйг хэлэх юун...

Гуравт, олон намын тогтолцоонд институцийн хэмжээнд заавал гарч ирэх жам ёстой гуравдахь сөрөг хүчин гарч ирэхдээ үзэл баримтлалаа зөвхөн эрх баригч намыг л үзэн ядах үзэлд тулгуурласан нь хэт явцуу сэтгэлгээ, хэт ядуу бодлолд барингалгагдаж, үндэстэний дайсгалыг л дэвэрлэхэд дэм өгөхөөс цааш гарахгүй үйлдэл болжээ. Энэ нь мөн л дээрхийн нэгэн адил нөлөөг төрийн тусгаар тогтнолд учруулж байнаа.

Дөрөвт, Монгол даяар үүрэг хариуцлагаа эс ойлгож, бүх нийтээрээ зөвхөн эрхээ л шаардацгааж дураараа дургих явдал дэвэрсэн нь засаглал сулрахад хүртэсэн. Энэ бас л тусгаар тогтнолд сайнаар нөлөөлөх эд эд биш билээ.

Тавд, хууль мөрдүүлэх механизм ардчилсан нийгэмд ч чухал зүйл байдгийг орхигдуулснаас олноороо төрөн гарч буй хууль дүрэм, эрхийн актууд эрээн цаас төдий зүйлс болсон. Энэ бол

анархизмыг төрүүлдэг гол замын нэг юм.

Зургаад, хүний эрхийн ардчилал бас засаглалыг сулруул хууль, ёс суртахууныг доройтуулдаг давхар нөлөөтэйг тооцон хачадсангүй. Эртний уламжлалтай ёс суртахууны үнэт зүйл уст алга болж, хар амиа хичээх, зоосны нүхээр бүхнийг харах, хуур мэхлэх, авилгалд идэгдэх, эрхээ шаардаж цээжээ дэлдэх явдгаарсан нь нийгмийн харилцааг хэвргэжүүлж, эх орноо хайрлах тусгаар тогтнолоо эрхэмлэн дээдлэх, үндэстэнийхээ эрх ашгийг мэдэрэх зэрэг хүмүүсийн мэдрэмж, оюун санааны үнэт зүйлсийг алхам алхмаар үгүй хийх боллоо. Энд төрийн хатуу бодлого, хүмүүжлийн хатуу боловсрол байх ёстойг төр өөрөө төдийгүй төрийг бүрдүүлэгч хүмүүс хараа хяналтаасаа алдаж явцуурчээ.

Долоод, ардчиллын зайлшгүй бүрэлдэхүүн хэсэг болс чөлөөт хэвлэл манайд зүй ёсоороо бүрэлдэн тогтож чадсангүй. Харин бидний дунд ёс суртахууны болон оюун санааны аливаа ариун үнэт зүйлсээс антид хамгийн ухамсаргүй хэвлэл бүрэлдэ тогтож, доромжлол, гүтгэлэг, гүжирдэл, бухимдалт, хов жи аймшиг, чочирдуулалт, хиймэл дуулианаар нийгмийг үерлүүлг өөрсдийнхөө гарт дөрөвдөгч засаглал байна хэмээн орилцсоо буй нь үнэн хэрэг дээрээ бүх нийтийн хардлага сэрдэл, үл итгэлцээ хувь хүнийг үнэ цэнээ алдаж зөвхөн нийгмийн амьтан төдийд үзэ сэтгэхэд үйлчилж байна. Иймд хүний ухамсрын жолоодлого бүк өөрөө өөрийгөө удирдах ёс голлодог ардчилсан чөлөөт байдла Монгол хүний зан чанарын сайн талыг сулруулж, нэн муу тал бүк догдогуур долигнуур, атаач жөтөөч, матаач ухаач, бие биеэ хэмлэ эвдрэлцдэг занг дэвэргэж болзошгүйг урьдчилан харж чадсангүй. Энэ бол үндэстэн өөрийнхөө дүр төрхийг алдаж устаж үгүй болохо хүргэх үүд хаалга гарцаагүй мөн.

Наймд, өрнөдийн маягийн хүний эрхийн тухай ойлголтыг нийгэмд хэт түгээх нь зөвхөн эрхээ эхэлж ухамсарлах талаа хөгжсөн сэтгэхүйтэй ард түмэнд буруугаар нөлөөлж, өөрийнхө муу сайн аяг зан бүрийг хүний эрх хэмээн ойлгож, цээжээ дэлдэ дураараа дургиж, засаглал, хууль өөдөө нүллимдэг нөхцөл бүрдэ боломж тавьж өгдөггүйг урьдаас ойлгосонгүй. Энэ бол төрийг удирдлагагүй анархи байдлыг үүсгэх гол зам мөн.

Энэ бүхэн Монголын ардчиллыг аргагүй л доошоо гулгахаа хүргэж нийгэмд анархи харилцаа, анархи сэтгэлгээ голлохо

Ж.Бор

"Монголын "аргичлал" нэгдэл анархи руу гулсаа"

сүргээжээ. Шилжилтийн үеийн онцгой байдлын улмаас төр энэ байдал дээр хяналтаа бүрэн алджээ. Гэтэл төр болж өгвөл ямар ч ерд өөрийнхөө функцгүй гүйцэтгэж байх ёстой. Хэрвээ хяналтаа алдсан бол маш түргэн сэргээн тогтоох чадвартай байх ёстой.

Эдүгээ Монголд ардчиллын шилжилтийн үе өнгөрч байна. Гэдээ төр хяналт, зохицуулалтынхаа апаратыг сэргээн ангагтахгүй бол энэ үе Монгол орны хувьд хязгааргүй үргэлжилж магадгүй юм. Монголд дутагдаж буй цорын ганц зүйл бол төр мөн. Монголд илүүдэж буй цорын ганц зүйл бол анархи мөн. Тиймээс Монгол хүний хувьд төр минь сэргээч, бүхнийг эвээл дороо авч Монголын төрийн уламжлалын дагуу "иргэний амь төрдөө, төрийн амь иргэндээ" гэдэг ёсыг сэргээгээч хэмээн мөргөнөм.

Төрийн сүлд өршөөг!

**ГАДААД БОДЛОГО, ДИПЛОМАТ АЖИЛЛАГААНЫ
ЗАЛГАМЖ, НЭГДМЭЛ ЧАНАРЫН ТУХАЙ
ӨГТҮҮЛЭХ НЬ***

**МУИС, ОУХС-ийн профессор,
доктор (Ph.D) Д.Цолмон**

Аливаа улсын гадаад бодлого, дипломат үйл ажиллагаа хоёр ягт холбоотой бөгөөд гадаад бодлого нь харьцангуй тогтвортой, хүн ардаа энх тунх, элбэг хангалуун аж төрөх, дэлхийн улс төрчүүдийн дотор зохих байр сууриа эзлэж үндэсний эрх ашгаа дээдлэх чиглэлтэй байдаг билээ. Ухаантай, эх оронч үзэлтэй төрийн томоохон зүтгэлтэн, улс төрийн бодлогыг боловсруулагчид мөнхөд орших үндэсний ашиг сонирхлыг эрхэмлэн дээдэлж тэр нь хожмын үйлсийн мөнхийн жигүүр болсон авай. АНУ-ын нэрт улс төрч, соён гэгээрүүлэгч Бенжамин Франклин, Томас Жефферсон нар болон сонгодог дипломат уламжлалтай Английн торд Палымерстон, ерөнхий сайд Черчилль, Францын ерөнхийлөгч Де Голль нарын гадаад бодлогын талаар хэлсэн үг, бүтээлүүдэд ийм санаа нь нэвт шингэсэн байдаг.

*Эл өгүүлэл "Өнөөдөр" сонины 2000 оны 10-р сарын 27-ны дугаарт хэвлэгдсэн.

Д.Цолмон

"Гадаад бодлого, дипломат ажиллагааны залгамж, нэгдмэл чанарын тухай өгүүлэх нь"